


2 Орчны эрүүл ахуйн асуудлыг ойлгож, хүмүүсийг татан оролцуулах нь

Энэ бүлэгт

Орчны эрүүл ахуйн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах нь.....	18
Өөрчлөлт хийхэд цаг хугацаа шаардагддаг.....	19
Суралцах, олон нийтийг татан оролцуулах үйл ажиллагаа	20
Эмэгтэйчүүдийн дуу хоолой хэрэгтэй	20
Чиглүүлсэн хэлэлцүүлэг	21
Орон нутгийн газрын зураг хийх	21
Орон нутгийн оршин суугчдын хэрэгцээг хэрхэн мэдэж авах вэ?	21
Эрүүл мэндийн явган аялал	22
Цаг хугацааны туршид гарсан өөрчлөлтүүд.....	22
Зургаар дүрслэх үйл ажиллагаа.....	22
Олон нийтийн судалгаа	23
Театр	23
Ямар үйл ажиллагааг хэзээ ашиглаж болох тухай зөвлөмж	25

Хуудас

Орчны эрүүл ахуйн асуудлыг ойлгож, хүмүүсийг татан оролцуулах нь



Глория болон эрүүл мэндийг хамгаалагчид Манглалалтогийн олон хүмүүс, эргэн тойрны тосгонуудын оршин суугчид өвчин тусч байгааг анзааран маш хурдан хугацааны дотор холер өвчний аюулыг олж мэдсэн. Тэгээд энэ өвчний тархалтын гол шалтгаан нь орчны бохирдлын асуудал буюу усны бохирдол байсан гэдгийг олж тогтоосон. Эрүүл мэндийн ажилтнууд болон тосгоны эрүүл ахуйн сургагч багш нар айлаас айлд очиж, хүн бүхэнд асуудлаа шийдэхэд нь тусалсан. Ийм анхан шатны зөвөлгөө тусламж үзүүлснээр тосгоны хүн бүхний итгэлийг олж авч, холер болон бусад өвчний эсрэг цаашдын хамтын ажиллагааны хөрс суурийг тавьж чаджээ.

Олон нийтийн оролцоо, иргэний боловсролын тусламжтайгаар олон нийтэд тулгарч байгаа байгаль орчны асуудлыг гарган ирж, түүнийг сайжруулах талаар ярилцаж эхэлсэн. Асуудлыг шийдвэрлэж сайжруулах тутам тосгоны хүмүүс өөртөө илүү итгэлтэй болж, өөрсдийнхөө амьдралыг өөрчилж чадна гэдэгтэй итгэл төгс болсон.

Эрүүл мэндийн асуудлын шалтгааныг олохын тулд олон асуулт тавьж, янз бүрийн замаар мэдээлэл цуглуулах шаардлагатай. Хөршүүд болон олон нийтийн дунд зарим асуудлаар хурц маргаан өрнөдөг ба шийдвэрлэх арга замыг гаргахад удаан хугацааны хэлэлцээ яриа, тэмцэл үүсдэг.

Иргэдийн нөхөрлөл, орон нутгийнхан тус бүр амьдралаа өөрчлөх өөрсдийн арга замыг олохдоо янз бүрийн үйл ажиллагааг ашигладаг. “Эрүүл мэндийг хүмүүст” хэмээх төслийн туршлагауд иргэдийн нөхөрлөлд эрүүл мэндийн асуудлын үндсэн шалтгааныг олох, түүнийг өөрчлөхөд нь үлгэр жишээ болж чадах юм.

Орчны эрүүл ахуйн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах нь

Экваторын эргийн шавартай толгодын ойролцоо амьдарч буй иргэд олон жилийн ядуурал, алслагдмал байдлаасаа залхсан байлаа. Гэхдээ тэд өөрсдийнхөө амьдралыг яаж сайжруулж чадахаа мэддэггүй байв. Амьдрал нь өдөр бүр хүнд хүчир болсон ч, цаашдаа түүнийг сайжруулах талаар итгэл байхгүй, бас төлөвлөгөө ч байхгүй байлаа. Холер хэмээх гэнэтийн аюултай тулгарах үед “Эрүүл мэндийг хүмүүст” төслийн ажилтнууд болон Глория олон хүний амийг аварч тусалжээ. Тосгоны хүмүүсийн эрүүл мэндийг хамтран хамгаалж чадсан нь тосгоны олон оршин суугчдад бие биетэйгээ хамтран ажиллах итгэл төрүүлжээ.

Хүчтэй үер бууж, тосгоны цэвэр усны байгууламжуудыг эвдсэний дараа тэд мөн л хамтран ажиллаж үерийн учруулсан хохирол гэмтлийг засч чадав. Үүний дараа тэд бусад асуудлаа шийдэхээр хамтарч эхэлсэн юм. Энэхүү үйл ажиллагаа нь оршин суугчдыг эрүүл байлгах чиглэлд үргэлжилж, тэд оршин суугчдын өнөөдрийн болон ирээдүйн эрүүл мэндийн талаар хамтран ажиллаж эхлэв.

Учир шалтгааныг ойлгохын төлөө ажилла

Эрүүл мэндийн асуудлууд маш олон зүйлээс шалтгаалж болно: өвчний нян, хортой химийн бодис, осол аваар, өлсгөлөн, хэт хүйтэн буюу хэт халуун болон бусад. Өвчний шууд учир шалтгаанууд гэж бий. Өвчний шууд шалтгаанаас гадна суурь шалтгаан гэж бий. Суурь учир шалтгааныг тодруулж чадах нь эрүүл мэндийн асуудлыг удаан хугацаанд шийдвэрлэхэд зориулан юу хийх ёстойг зааж өгдөг. Глория түрүүнд нь “Гэвч яагаад” гэдэг ажиллагаа зохион байгуулж, хүмүүсийн дунд хэлэлцүүлэг явуулан нэгэн асуудалд гарсан олон учир шалтгааныг тодруулж чадсаныг та харсан.



Өөрчлөлт хийхэд цаг хугацаа шаардагддаг

Орчны эрүүл ахуйг сайжруулах ажил богино хугацаанд хурдан явагдаж чаддаггүй. Манглалалтод гэхэд эрүүл ахуйн ажилчид эхлээд хүмүүст шингэн дутагдахад өгдөг уусмалыг тараан өгч эмчилсэн. Дараа нь тэд усыг цэвэр болгох, цэвэр усыг хамгаалахад зориулсан ажил хийсэн. Түүний дараа тэд олон нийтийг зохион байгуулж, цэвэр усны шинэ систем, аюулгүй жорлон байгуулсан. Үүний дараа их хэмжээний үер болж тосгоны бүх байгууламж нурсны дараа л хөрсний элэгдэл, ой сүйтгэлтэй холбоотой хурц асуудлыг тосгоныхон ойлгоцгоосон. Энэ асуудлуудыг ойлгосон байх нь цаашдаа өөрчлөлтүүдийг үргэлжлүүлэн хийхэд чухал байлаа. Амжилтад хүрэхийн өмнө бид хэд хэдэн удаа алдаж, тэмцэж байдаг. Бидний хийж байгаа зүйл үр дүнд хүрэхгүй байгааг харсны дараа л бид ихэвчлэн яагаад гэж асуудаг.

Орчны эрүүл мэндийг сайжруулах ажил маш шаардлагатай. Тэвчээртэй байх хэрэгтэй. Заримдаа хэтэрхий хурдан хийгдсэн өөрчлөлт хурдан алга болдог учир нухацтай сайн өөрчлөлтийг хийхийн тулд цайгагүй, үл суурьтай байх ёстой.

Орчны эрүүл мэндийг сайжруулахад зайлшгүй тулгамдсан дөрвөн өөрчлөлтийг хийх ёстой байдаг. Иймээс үүнд маш их цаг ордог. Үүнд:

1. Бид усны систем, орон байр болон өөрсдийнхөө барьж байгуулж байгаа бусад зүйлүүдээ өөрчилж сайжруулах хэрэгтэй болдог. **(дэд бүтэц)**
2. Бид худалдан авч байгаа зүйлүүдээ өөрчилж, муу хоол хүнс авахгүй байх, байгаль орчинд хортой цэвэрлэх бодис хэрэглэхгүй байх, гялгар уутанд боодолтой бүтээгдэхүүнийг авахгүй байх зэрэг худалдан авах хэвшлээ өөрчлөх хэрэгтэй болдог. **(хэрэглээ)**
3. Бид өөрсдийнхөө дур сонирхол, өдөр тутмын хэвшлээ өөрчилж, гараа байнга угаах, хогоо ялгаж заримыг нь дахин хэрэглэх, тариа ногоогоо өөр хэлбэрээр тарих зэргээр өөрчлөгдөх хэрэгтэй болдог. **(хэвшмэл үйлдлээ)**
4. Орон нутгийн оршин суугчид, аж ахуйн нэгж компаниуд, төвөөс удирдаж буй засгийн газар болон бусад шийдвэр гаргах байгууллагууд байгаль орчны талаар шийдвэр гаргах эрх мэдлээ хэрхэн хуваарилах ажил дээр өөрчлөлт гаргах хэрэгтэй болдог.

Энэ бүх өөрчлөлтүүдэд цаг хугацаа шаардагддаг ба тэд бие биендээ нөлөөлдөг.



Бид дэлхий ертөнцийг алар байгаагаар гэж хүсч байна. Тийм өөрчлөлтийг өөрсдөдөө хийх ёстой.

Залуучуудтай ажилла
Өөрчлөлтийг үргэлжлүүлдэг байа гэвэл залуу хүмүүстэй ажиллах ёстой. Яагаад гэвэл, тэд сурсан зүйлсээ ирээдүй рүү тээж очдог юм. Бид өөрсдөө хэдэн настай байхаасаа үл хамааран өөрсдөө залуу хүн шиг байж бас чаддаг. Бид залуу хүн шиг суралцаж, шинэ зүйлийг туршиж чадна.

Суралцах, олон нийтийг татан оролцуулах үйл ажиллагаа

Эрүүл мэндийн асуудлуудын суурь шалтгааныг ойлгоход бүлгийн үйл ажиллагаа тусалж чаддаг. Чухамхүү бүлгийн үйл ажиллагаан дээр өөрчлөлтийн төлөвлөгөө гарч ирдэг. Ямар хэлбэрийн үйл ажиллагаа явуулах вэ гэдэг та юу мэдэхийг хүсч байна, юу хийхийг зорьж байна, ямар нөөц бололцоо байна гэдгээс хамаарна. Хамтын үйл ажиллагаа нь дараахь үр дүнд хүрч чадна:

- Хүмүүсийг нийтлэг асуудлаа ойлгохын төлөө хамтран ажиллуулж чаддаг.
- Хүмүүст юу хамгийн чухал байгааг олж тогтоодог.
- Эрүүл мэндийн асуудлыг үүсгэж байгаа зүйлсийн талаар мэдээлэл цуглуулж авдаг.
- Хүмүүсийн эрүүл мэндийн асуудлын шууд болон суурь учир шалтгаануудыг олж гаргахын тулд асуудлуудыг задлан шинжилдэг.
- Нөхөрлөл, олон нийтийн дунд байгаа бүх төрлийн байр сууриудыг нэгтгэж цуглуулдаг. Хэрэв нөхөрлөл, олон нийт дотор зарим бүлгийн санаа бодол орхигдвол төсөл амжилттай болж чаддаггүй. Хүмүүсийн санаа бодол орхигдвол хүмүүс уг ажилд оролцох дургүй болдог. Орчны эрүүл ахуйн асуудал гэдэг бол хэзээд олон нийтийн иргэдийн нөхөрлөлийн үйл хэрэг байдаг. Ийм учраас байдлыг сайжруулахад хүмүүс заавал хамтран ажиллах хэрэгтэй болдог. Хүмүүсийн шийдэх асуудал нь хурц халдварт өвчний тархалтыг багасгах, нийтийн цэцэрлэгт хүрээлэн байгуулах, үйлдвэрийн орчинд ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй орчныг сайжруулах болон бусад орчны эрүүл мэндтэй холбоотой асуудлыг сайжруулах гээд ямар ч асуудал зорилго байлаа гэсэн олон хүмүүс энэ асуудлыг шийдвэрлэхэд олуулаа оролцох тусам асуудлыг амжилттай шийдвэрлэж чадна.

Эмэгтэйчүүдийн дуу хоолой хэрэгтэй

Зарим орон нутагт эмэгтэйчүүд, охидыг яриа хэлэлцээнд идэвхтэй оролцуулахын тулд эмэгтэйчүүдийн бүлэг байгуулж болдог. Эмэгтэйчүүдийн бүлэг нь өөрсдөдөө тулгардаг асуудлыг нийтийн том бүлэгт зориулан боловруулж өгдөг. Ийм маягаар эмэгтэйчүүд, охидод тулгардаг асуудлыг нийт орон нутгийн хэмжээний асуудал



дотор хүчтэй хэлбэрээр оруулж ирж тавьдаг. Эмэгтэйчүүд охидод дуу хоолойгоо хүчтэй илэрхийлэх боломж олгосноор, тэдэнд удирдах ур чадвар төлөвшүүлснээр нийт нөхөрлөл орон нутаг хүчтэй болдог.

Чиглүүлсэн хэлэлцүүлэг

Эрүүл мэндийн асуудлыг хамтдаа ойлгохын тулд хүмүүс бие биентэйгээ ярих шаардлагатай. Чиглүүлсэн хэлэлцүүлэг гэдэг нь хэсэг бүлэг хүмүүс нэг нэгэнтэйгээ ярихдаа тодорхой асуултад хариулт өгөх замаар ярихыг хэлнэ. Жишээ нь, “Гэвч яагаад” хэмээх үйл ажиллагаа нь чиглүүлсэн хэлэлцүүлгийн нэг хэлбэр юм.

Хэлэлцүүлгийн схемийг зурах, биет зүйлийг газрын зураг дээр хөдөлгөж ярих зэрэг нь чиглүүлсэн ярилцлагын өөр нэг хэлбэрүүд юм. Яриа хэлэлцүүлгийг чиглүүлж өгдөг хүнийг идэвхжүүлэгч буюу хөтлөгч гэж нэрлэдэг. Энэхүү номонд орсон дасгалын ихэнх нь идэвхжүүлэгчтэйгээр хийх дасгалууд юм. Идэвхжүүлэгчийн тусламжтайгаар хүмүүс бүгд жигд оролцож, өөрсдийн дуу хоолойг үйл ажиллагаа болгоход чиглүүлнэ.

Орон нутгийн газрын зураг хийх

Орон нутгийн газрын зураг хийх гэдэг нь иргэдийн хамтран хийдэг нэгэн төрлийн ажил бөгөөд энэхүү газрын зурган дээр тэд юу харж байгаагаа тэмдэглэж, өөрсдийнхөө орон нутгийн нөхцөл байдлыг хамтдаа ойлгож авцгаадаг. Орон нутгийн эрүүл мэндийн газрын зураг хийж авснаар доорх зүйлийг мэдэж авдаг:

- Эрүүл мэндийн асуудлууд **хаана байна вэ?**
- Энэ асуудлууд **хэнд нөлөөлөх вэ?**
- Энэ эрүүл мэндийн асуудлууд орчны байгаль орчны нөхцөл байдлаас болж **хэрхэн учирч болох вэ?**

Ингэж газрын зураг хийх нь орон нутгийн хүмүүст эрүүл мэндийн асуудлыг ойлгоход нь тусалж, эрүүл мэндийн асуудлын суурь шалтгааныг тодорхойлж, цаашид орон нутгийн хөгжил өөрчлөгдөх тусам нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхийг олж харахад нь туслана. Газрын зурагнаас хүмүүс орчин тойрондоо байгаа чухал нөөцүүдийг болон хүчтэй талуудаа олж харах бололцоотой. Газрын зураг хийснээр хүмүүс орчин тойрондоо байгаа чухал үнэт зүйлс, уламжлал, ариун газруудынхаа тухай мэдэж, түүнийг хамгаалах алхам хийж эхэлнэ. (Жишээг 74, 170, 449-р хуудаснаас үзнэ үү)



Орон нутгийн оршин суугчдын хэрэгцээг хэрхэн мэдэж авах вэ?

Орон нутагт тулгарч байгаа асуудлууд болон түүнийг хэрхэн зүй зохистой шийдэх талаар хүмүүс ихэвчлэн өөр өөр байр суурьтай байдаг. Хүмүүсийг чухал гэж үзсэн

цөөхөн асуудалд чиглүүлэх, түүнийг нь олж тодорхойлох, удаан хугацаанд тэр асуудал дээр хамтран ажиллуулахад шаардлагатай туслалцаа үзүүлэхийг “Хэрэгцээ шаардлагын үнэлгээ” хэмээн нэрлэдэг (хэрэгцээ шаардлагын үнэлгээг тогтоох жишээг 78, 116, 227-р хуудсанд өгүүлнэ). Хэрэгцээ шаардлагын үнэлгээг сайн хийх процесс нь өөрөө төлөвлөгөө хийх явцад хүн бүхний хэрэгцээг тусгах, хүн бүхний ур чадварыг бүрэн ашиглахад туслалцаа үзүүлдэг.

Эрүүл мэндийн явган аялал

Эрүүл мэндийн явган аялалын үеэр хүмүүс өөрийнхөө орчны амьдралыг ойроос харж чаддаг. Тэд өөрсдийнх нь эрүүл мэндэд аюул учруулж болох асуудлын шалтгааныг олж харах, усны бохир эх үүсвэрийг олж мэдэх, ус бохирдуулагч бизнес хаана байгааг тогтоох, эсвэл түлээ түлшний дутагдал хаана байгааг тогтоох зэрэг мэдээллүүдийг явган аялалын туршид олж мэднэ. Хүмүүс явган аялалын үеэр өөрсдийнхөө олж харж байгааг бусдынхтай харьцуулан эрүүл мэндийн асуудлын шалтгаануудын талаар өргөн мэдлэгтэй болдог. Дараа нь тэд хамтарсан шийдэл олохын тулд нийлж ажилладаг. Хүмүүс олноороо энэ ажилд оролцох тусмаа сайн байдаг (эрүүл мэндийн явган аялалын тухай 397, 449-р хуудаснаас үзнэ үү).



Цаг хугацааны туршид гарсан өөрчлөлтүүд

Асуудлыг ойлгох, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох бас нэг хэлбэр нь өнгөрснийг одоотой харьцуулах харьцуулалт юм. Өнгөрснийг одоотой харьцуулсны дараа ирээдүй ямар болохыг бодож үзнэ. Ингэхийн тулд өөрийн орон нутагт байгаа ахмад хүмүүсээр өнгөрсөнд болсон зүйлийг яриулж авах ёстой. Энэ ажлыг залуу хүмүүс хийж, ахмад хүмүүстэйгээ ойлголцох нь их чухал байдаг. Ийм ярилцлага хийх нь орон нутгийн үнэтэй өв уламжлалыг хадгалж үргэлжлүүлэхэд чухал тус дэм болно. Тухайн орон нутгийн цаг хугацааны хүснэгтийг гаргах нь орон нутаг хэрхэн өөрчлөгдөж, үеэс үед яаж уламжлагдаж байгааг ойлгоход туслана.

Үүний дотор тухайн орон нутагт болсон чухал бүтээн байгуулалтуудыг тэмдэглэх ёстой. Жишээлбэл, зам яаж тавьсан, үйлдвэрүүд хэзээ нээгдсэн, усан сан хэзээ байгуулагдсан гэх зэргийг мэдэж тэмдэглэх ёстой. Орчны нөхцөл байдлын өөрчлөлтийг ингэж цаг хугацаагаар нь тэмдэглэж газрын зурагт оруулах нь орон нутгийн түүхийг зураг, газрын зураг, цаг хугацааны хүснэгтээр болон бусад хэлбэрээр харуулж өгнө. Орон нутгийн орчны нөхцөл байдлын өөрчлөлтийн энэхүү зураг нь тухайн орон нутгийн бэлчээрийн талбай, хөдөө аж ахуйн фермүүд, ой, барилга байгууламж, төв суурин, гол нууруудыг оруулж, тэдгээрийн өөрчлөлтийг тэмдэглэх ёстой. (жишээг 170-р хуудаснаас үзнэ үү)

Зургаар дүрслэх үйл ажиллагаа

Зураг зурах, зураг харах зэрэг үйл ажиллагаанууд нь бидний өөр хэлбэрээр олж харж чадахгүй асуудлуудыг олж харахад туслана. Зураг зурах ажлыг чиглүүлсэн хэлэлцүүлэг хийхдээ анхлан хэрэглэж болох ба цаашдаа зургаар асуудлаа дүрсэлж

танилцуулах нь уншиж, бичиж чаддаггүй буюу сайн ярьж чаддаггүй олон хүмүүст өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь туслана. (жишээг 56, 60, 281-р хуудаснаас үзнэ үү)

Зарим иргэний нөхөрлөлүүд байшингийн ханан дээр хамтран том зураг зурдаг. Энэ том зурагнуудаараа өөрсдөдөө тулгарсан асуудлуудыг илэрхийлж, сайн ирээдүй, итгэл найдварыг билэгддэг.



Олон нийтийн судалгаа

Олон нийтийн дунд судалгаа явуулах нь мэдээллийг зохион байгуулалттайгаар цуглуулах нэгэн арга юм. Энэ аргаар хүмүүсийн дунд байгаа эрүүл мэндийн асуудлуудыг олж тогтоон тэдгээр асуудлын талаар хүмүүсийн бодож байгаа байр суурь, итгэл үнэмшлийн ижил төстэй болон ялгаатай байдлыг тогтоох, эсвэл янз бүрийн төлөвлөгөө үйл ажиллагааг дэмжиж байгаа эсэхийг хэмжих хэмжүүр болгодог.



Судалгааг явуулахдаа судалгаанд оролцож байгаа хүн бүхнээс ижил асуулт асуудаг. Судалгааг айлын гэрт, ажлын газар, сургууль, сүм хийд болон бусад олон нийт цугларсан газарт авч болох ба утсаар юм уу захидал харилцаагаар ч судалгаа авч болно. Судалгаа нь хүмүүст үзэл бодлоо илэрхийлэх, хурал цуглаанд очихгүйгээр санаа бодлоо чөлөөтэй дэвшүүлэхэд нь туслана. Зарим үед хүмүүс уулзалтад очихоос эмээдэг. Олны өмнө үзэл бодлоо хэлэхээс айдаг хүмүүс нэрээ бичилгүйгээр судалгаанд оролцож үзэл бодлоо илэрхийлэхдээ илүү дуртай байдаг. Орон нутгийн нөхөрлөлүүдийн эрүүл мэндийн судалгааг авах жишээг 506, 511-р хуудаснаас үзнэ үү.


Театр

Театр нь асуудлыг уудлан гаргаж, шийдлийг санал болгонгоо хүмүүсийг хөгжөөж баясгах хэлбэр байдаг. Хүмүүс өөрсдөдөө тохиолдсон үйл явдал, бусдад тохиолдож болох зүйлүүдийг ургуулан бодож жүжиглэж болно. Заримдаа асуудал зөрчлүүдийг хурцаар гаргахдаа өөр хүний дүрд, өөр газар, өөр цаг хугацааг дүрсэлж жүжиглэнэ.

Социодрам буюу нийгмийн драм

Социодрам нь хүмүүст тохиолдож буй асуудлуудын учир шалтгаан, үр дагаврыг жүжигчилэн үзүүлнэ. Энэ номын 192-194 дугаар хуудсанд ойн нөөцийг ашиглах талаар гарч буй зөрчлийг социодрамын аргаар хэрхэн дүрсэлсэн жишээг оруулав. Социодрам нь хүний сэтгэл хөдлөлийг харуулдаг. Орон нутгийн зохион байгуулагч нар социодрамыг өндөрлөхдөө хүмүүсийн хамтарсан уриа, дуулах дуртай дуугаар төгсгөж, хамтын ажиллагааг үүсгэдэг.


Заримдаа театрчилсан жүжиг нь үзэж байгаа хүн, жүжиглэж байгаа хүмүүсийг хамт оролцуулдаг. Үзэгчдийн дундаас хэн нь ч гэсэн жүжигчнийг зогс хэмээн зогсоож, жүжигчний оронд асуудлыг шийдэх өөр гарцыг санал болгодог. Заримдаа ийм жүжигчилсэн тоглолтын аргаар ямар ч эрх мэдэлгүй байгаа хүмүүс асуудал шийдвэрлэхэд оролцох арга замаа олж авч, үзэл бодлоо илэрхийлдэг.



Ямар ч өгүүлэл зохиолыг социодрам болгон өөрчилж болох ба гагцхүү социодрамын жүжгийн дүрүүд болон тэнд шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлсон байх ёстой.

Дүрийг жүжиглэх

Дүрийг жүжиглэн тоглох нь социодрамтай адилхан их бэлтгэл шаарддаггүй бөгөөд аливаа нэгэн зөрчилтэй асуудлын өөр өөр байр суурийг гаргаж ирэн зөрчлийг шийдвэрлэхэд туслана. Хүмүүс амьдрал дээр бодитойгоор тохиолдож буй асуудлуудад оролцож буй хүмүүсийн дүрийг жүжиглэн гаргаж, тэд тухайн нөхцөл байдалд ямар үйлдэл хийхийг жүжиглэн харуулна. Ингэж жүжиглэсэн тоглолтын дараа хэлэлцүүлэг явуулж, тухайн дүрүүд яагаад ийм үйлдэл хийж байгаа талаар хэлэлцэнэ. Эрх мэдэлтэй хүмүүсийн үйлдлийг өөрчлөх нь тайзан дээр тоглох үед амархан боловч бодит амьдрал дээр маш хэцүү зүйл. Тайзан дээр дүрийг бүтээснээрээ тухайн дүрүүдийн бодит илрэл болсон эрх мэдэлтнүүдийг өөрчлөхөд юу шаардлагатай вэ гэдгийг ойлгож авахад туслана.




Хүүхэлдэйн жүжиг

Орон нутагт байгаа зөрчилтэй асуудлуудыг илэрхийлэн гаргахын тулд хүүхэлдэй ашиглаж болно. Хүүхэлдэйнүүд нь хүмүүсийг инээлгэж, орон нутагт байгаа асуудлыг тодорхой гаргаж өгч чаддаг. Зарим хүмүүс хүүхэлдэйгээр тоглуулж өөрсдөө ил гарахгүйгээр асуудлыг тайлбарлах дуртай байдаг.

Ямар үйл ажиллагааг хэзээ ашиглаж болох тухай зөвлөмж

Энэхүү номонд дурьдагдаж буй олон нийтийн үйл ажиллагаанууд нь орчны эрүүл ахуйн тодорхой ач холбогдол бүхий асуудлуудыг шийдэхэд өөр өөр байдлаар туслана. Эдгээр үйл ажиллагааны туршлага нь танай өөрийн орон нутагт дараахь асуудлыг шийдвэрлэхэд чиглэл болж чадна. Үүнд:

- Тодорхой асуудлын талаар яриа хэлэлцээрийг эхлүүлэх, тодорхой сэдвийг хөндөхөд туслана. /65, 85, 226, 466-р хуудсыг үз/
- Нийгмийн бүлгүүдийг шийдвэр гаргахад буюу янз бүрийн хэрэгцээ, шийдлүүдээс сонголт хийхэд нь туслана. /144, 197-р хуудсыг үз/
- Мэдээлэл цуглуулах, мэдлэгээ хуваалцах, байгаль орчныхоо асуудалд идэвхтэй хандахад туслана /56, 60, 397, 449-р хуудсыг үз/.
- Шинэ санаанаас суралцах, хуучны сайн зүйлийг дахин суралцах, хуучин уламжлалыг шинэ аргаар дахин олж танихад туслана /164, 290, 295, 342, 520-р хуудсыг үз/.
- Тодорхой асуудлыг шийдэхийн тулд зохион байгуулалт хийж эхлэхэд туслана



/116, 170, 227, 281-р хуудсыг үз/.

- Хэцүү асуудлын талаар сургалт явуулах, хурц зөрчилтэй асуудлыг ойлгож шийдвэрлэхэд туслана / 116, 192-р хуудсыг үз/.

Орон нутгийн газрын зургийг эрүүл мэндийн явган аялалын өмнө, явган аялалын үеэр болон дараа нь хийх зэрэг зарим үйл ажиллагааг хамтран гүйцэтгэж болно. Мөн дүрд орж жүжиглэх, олон нийтийн хэрэгцээ шаардлагын үнэлгээний үйл ажиллагаа зэргийг



хамтруулан хийж болно. Хамгийн чухал нь, эдгээр үйл ажиллагаанууд нь хүмүүст мэдээлэл цуглуулах, мэдлэгээ хуваалцах, ойлголтоо гүнзгийрүүлэхэд нь туслалх ёстой. Энэхүү үйл ажиллагаанууд нь орон нутгийн иргэдийн зохион байгуулалт, эрх мэдлээ хэрэгжүүлэх, эрүүл мэндийнхээ суурь асуудлуудыг шийдвэрлэхэд нь дэмжлэг болох ёстой.

